



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/УСЧ

Улаанбаатар хот


**Чингэлтэй дүүргийн Цагдаагийн Хоёрдугаар
хэлтсийн балансаас шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэхь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус дансанд бүртгэлтэй нийт 76,201,019.5 /далан зургаан сая хоёр зуун нэг мянга арван есөн төгрөг, тавин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сүхбаатар дүүргийн Хоёрдугаар хэлтсийн балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн Хоёрдугаар хэлтэс /Ц.Сугаржав/-т зөвшөөрсүгэй.
2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сүхбаатар дүүргийн Хоёрдугаар хэлтэс /А.Наранбаатар/-т үүрэг болгосугай.
3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн Хоёрдугаар хэлтэс /Ц.Сугаржав/-т, Сүхбаатар дүүргийн Хоёрдугаар хэлтэс /А.Наранбаатар/-т тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001230



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 11 сарын 13 өдрийн А/УСН дүгээр тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсээс Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэст

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ			Хөрөнгө хүлээн авах байгууллага	
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл		Үлдэх хөрөнгө
1	Халаалтын тогоо	Kiturami	2016	ш	1	633,600.0	633,600.0	633,600.0	-	Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэс
2	Халаалтын зуух	Kiturami	2016	ш	1	75,567,419.5	75,567,419.5	17,212,579.0	58,354,840.5	
Машин, тоног төхөөрөмжийн дүн							76,201,019.5	17,846,179.0	58,354,840.5	
Нийт							76,201,019.5	17,846,179.0	58,354,840.5	